

УЛС ТӨР

САРД 360 ХҮН БНСУ-Д ВИЗНЫ ХУГАЦАА ХЭТРҮҮЛЭН ҮЛДЭЖ БАЙНА

II нүүрт

ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

ХҮССЭН ХИЧЭЭЛЭЭ СОНГОЖ
ЧАДААГҮЙ ХҮҮХДҮҮД ТУРШИЛТЫН
ЗОЛИОС БОЛСООР БАЙХ УУ...

VI-VII нүүрт

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР



Өдөр +20

Шөнө +6

Дугаарын 60 мөр

Хэдхэн паспорт хэвлэх тэнхээтэй байгаа


Ж.ОТГОНМЯГМАР

Гадаад паспорт, жолооны үнэмлэхний бэлдэл дууссанучраас хэвлэхгүй, ачаалалтай байна, хүлээгдэж байгаа гэх мэдээлэл энгийн үзэгдэл болоод удаж байна. Жил жилийн зуны дэлгэр цагтай зэрэгцээд буюу долдугаар сараас эхлэн гадаад паспорт авах гэсэн иргэдийн хөлд УБЕГ-ынхан дарагддаг. Манайхан гэсвэргүй зантайг ч хэлэх үү, дарааллаа булаалцалдан маргалдах, зодолдох, бүүр цаашлаад цонх шил хагалах явдал УБЕГ-т болдог нь нууц биш. Гэтэл сүүлийн үед ОХУ руу визгүй зорчдог болсонтой холбоотойгоор гадаад паспортын ачаалал буурахгүй үргэлжилсээр есдүгээр сартай золгодог боллоо.

Үргэлжлэл нь III нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

WSJ: ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ХУВЬД “ХАЛУУХАН БҮСГҮЙ” БАЙСАН МОНГОЛ



Б.ДАВАА

Монголын эдийн засгийн нөхцөл байдлыг хоёр хөршийн болоод дэлхийн томоохон хэвлэлүүд хэрхэн дүгнэн бичиж буйг “Монгол дэлхийн хэвлэлд” булангаараа тоймлон хүргэж байна.

WSJ: Хөрөнгө оруулагчдын хувьд “халуухан бүсгүй” байсан Монгол хаягдаж үлдэв

АНУ-ын томоохон хэвлэл

“Wall street journal” сонинд өрөндөө баригдаж, хөрөнгө оруулагчид нь зугтсаныг дээрх агуулга бүхний нийтлэлдээ тодотгожээ. Үүнд “Дэлхий дээр хөрөнгө оруулагчдын шинэ гарц олж харж чадаагүй нэгэн булан орших ажээ. Тэр нь Монгол. Учир нь тэд тэр буланд

Үргэлжлэл нь III нүүрт



“ШИНЭ ТӨГӨЛ”-д тавтай морил

Олон Улсын стандартад нийцсэн “Шинэ төгөл” цэцэрлэг “Маршал таун” хотхонд нээгдэж, 2016-2017 оны хичээлийн шинэ жилийн элсэлтээ авч эхэллээ. “Шинэ төгөл” цэцэрлэг нь нийслэлийн хамгийн цэвэр агаартай бүсэд өөрийн зориулалтын, бие даасан байрандаа танай хүүхдийг эрүүл, аюулгүй орчинд сургахын зэрэгцээ зөв монгол иргэн болж төлөвшихөд бэлтгэнэ.

АНГИ БҮРИЙГ КАМЕРЖУУЛСАН ТУЛ ТА ХҮҮХДЭЭ АЖИЛ БОЛОН ГЭРЭЭСЭЭ ХЯНАХ БОЛОМЖТОЙ.



Нэг ангид хоёр багштай ба анги дүүргэлт 15-20 хүүхэдтэй. Манай цэцэрлэг нь пластик ширээ, сандал, тавилга, тоглоомоостатгалзаж хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, байгалийн гаралтай цэцэрлэгийн стандартыг бүрэн хангасан модон ширээ, сандал, тавилгатайгаас гадна АНУ болон Европын сэтгэхүй хөгжүүлэх, сэдэвт, тоо тооллын, бие бялдар хөгжүүлэх тоглоом мөн Японы сургалтын хэрэглэгдэхүүнтэй. Сургалтын хөтөлбөрийн хувьд

сургуулийн өмнөх боловсролын ЦӨМ хөтөлбөрийг The Academy of English - ийн JOLLY KIDS 4-5 настай хүүхдэд зориулсан Англи хэлний сургалттай хослуулан хэрэгжүүлж амьдрах ухаан, онцлог юм.

Сургалтаараа хүүхдийг амьдрах ухаан, ёс заншил, урлаг соёл, байгаль болон хүрээлэн буй орчныг танин мэдэхэд сургахаас гадна хүүхдийн биеэ даах, аливаа асуудлыг өөрөө шийдэх, нийгэмших, баг хамт олноор ажиллах, бүтээлч чадварыг хөгжүүлнэ.

Түүнчлэн манай чадварлаг тогооч нарын бэлтгэсэн хоол нь зөвхөн хүүхдэд зориулсан байдаг төдийгүй байгалийн органик гаралтай, амин дэм, витаминаар баялаг, өөх тос багатай, шарж хуураагүй байдгаараа давуу талтай юм. Үүнээс гадна манай гал тогоо нь өндөр зэрэглэлийн Европын техник төхөөрөмжтэй тул хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй юм.

ТАНЫ БЯЦХАН ҮРС ЗӨВ МОНГОЛ ХҮН БОЛНО
Холбоо барих утас: 99094864, 99198435

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

Ц.ДАВААЦЭРЭН: “ЭРДЭНЭТ” ҮЙЛДВЭРИЙН ХУВЬЦААГ ХЭРХЭН ХУДАЛДСАН ТУХАЙ УИХ-Д ТАНИЛЦУУЛАХ БАЙХ

“Эрдэнэт” үйлдвэрийн ерөнхий захирал Ц.Даваацэрэнтэй цаг үеийн асуудлаар ярилцлаа.

-Оросын тал “Эрдэнэт” үйлдвэрийн өөрийн эзэмшдэг 49 хувийг зарж, манай талаас “Худалдаа хөгжлийн банк” авсан хэмээн сонгуулийн өмнө Ч.Сайханбилэг Ерөнхий сайдаар ажиллаж байх хугацаандаа мэдээлсэн. Сонгуулийн дараа энэ асуудлыг шалгана гэж байсан. Энэ асуудал юу болсон бэ?

“Эрдэнэт” үйлдвэрийн Оросын талын эзэмшдэг 49 хувийг арилжаалах асуудал хуулийн дагуу хийгдсэн гэж Оросын талаас албан ёсоор мэдэгдсэн. Харин Монголын талаас энэ үйл ажиллагаа хуулийн дагуу явсан уу гэдгийг УИХ-аас байгуулагдсан ажлын хэсэг шалгаж байгаа. Тэгэхээр энэ асуудлыг УИХ-ын төвшинд ярих байх. Ер нь Монгол, Орос улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрээр талууд өөрсдийн эзэмшиж байгаа хувийг зарах тохиолдолд хамгийн түрүүнд

нөгөө талдаа мэдэгдэнэ гэж заасан. Гэрээний дагуу ОХУ-аас өнгөрсөн зургадугаар сард тэдний эзэмшдэг 49 хувийг худалдаж авах санал ирсэн гэсэн. Тухайн үед манай Засгийн газар харну өгч, энэ гэрээ хэлэлцээр хийгдсэн гэж Оросын талаас албан ёсоор мэдэгдсэн. Миний хувьд гүйцэтгэх захирал учраас хувьцаатай холбоотой нарийн ширийн асуудлыг сайн мэдэхгүй байна. Ер нь энэ асуудлыг шалгаад УИХ дээр тайлан тавих байх.

Үргэлжлэл нь V нүүрт

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Ё.Манлайбаяр: Дамжин өнгөрөх транзит тээвэр 90 сая тоннд хүрвэл дахиад нэг “Оюутолгой”-той болно

Н.БАТЗАЯА

Монгол, Орос, Хятад гурван улсыг дамнанас төмөр замын тээврийн коридорыг хөгжүүлэх асуудлаар гурван талт хэлэлцээрийн гурав дахь удаагийн зөвлөлдөх уулзалт Төмөр замын удирдах газарт өчигдөр боллоо. Энэхүү уулзалтад Зам тээвэр хөгжлийн сайдын зөвлөх Ё.Манлайбаяр, БНХАУ-ын улсын төмөр замын газрын гадаад харилцааны газрын дарга Ван Жа Юу, ОХУ-ын холбооны төмөр замын орлогч дарга В.И.Мишук, Монголын төмөр зам ТӨХК-ийн төлөөлөл, Улаанбаатар төмөр зам ХНН нар оролцсон юм. Гурав дахь удаагийн зөвлөлдөх уулзалтаар талууд



Гэрэл зургийг Т.АРИУУЖИЙН

гурван улсын төрийн тэргүүн нарын өнгөрсөн зургадугаар сард Ташкент хотноо “Эдийн засгийн коридор” байгуулах хөтөлбөрийг баталсныг сайшааж, гурван улсын нутаг дэвсгэрийг дамнанас

төмөр замын тээврийн коридорыг хөгжүүлэх талаар санал солилцож, хамтарсан төлөвлөгөө, протоколын төслийг хэлэлцсэн.

Үргэлжлэл нь V нүүрт



ХААН банк

	Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2235.00	2248.00	ФУНТ	2933.00	3019.00
ЕВРО	2476.00	2555.00	РУБЛЬ	33.30	36.10
ИЕН	21.72	22.25	ЮАНЬ	333.00	336.80

Худалдаа хөгжлийн банк

	Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2237.00	2248.00	ФУНТ	2952.00	3037.00
ЕВРО	2487.00	2561.00	РУБЛЬ	33.61	36.62
ИЕН	21.67	22.40	ЮАНЬ	333.00	336.90

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

Ж.ОТГОН

Хуучин Гадаад харилцааны яамнаас зохион байгуулдаг байсан “Мэдээллийн цаг”-ийг Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил үргэлжлүүлэхээр шийдсэн байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын гадаад харилцаа, хамтын ажиллагааны талаар сард нэг удаа мэдээлэл хийх юм байна. Энэ удаагийн “Мэдээллийн цаг”-аар Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил, Гадаад худалдаа эдийн засаг, хамтын ажиллагааны газрын захирал В.Энхболд, Консулын газрын захирал Я.Ариунболд нар мэдээлэл хийлээ. Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил хэлэхдээ “2016-2020 оны Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр батлагдсан. Энэхүү хөтөлбөрт гадаад харилцааны чиглэлээр 13 асуудал тусгагдсан. Монгол Улс дэлхийн 186 улстай дипломат харилцаатай байдаг. Энэхүү харилцааг эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдааны эргэлтийг нэмэгдүүлэхэд чиглүүлэх зорилго тавьсан. Нэг ч гэсэн бизнес эрхлэгчдээ түнш олж өгөхийн төлөө ажиллах үүргийг дипломат төлөөлөгчийн газарт өгсөн. Дипломат төлөөлөгчийн газар ажиллаж байгаа хүмүүсийн ажлыг үүтээр дүгнэнэ. Хоёрдугаарт, Монгол Улсыг гадаадад сурталчлах, давтагдашгүй соёлын өвийг соёлын илч төлөөлөгчөөр дамжуулан сурталчлах ажилд онцгой анхаарах үүрэг даалгаврыг УИХ, Засгийн газраас өгсөн. Гуравдугаарт, Гадаадад ажиллаж амьдарч байгаа 130 мянган иргэний эрх ашгийг хамгаалах асуудал юм. Ингэхдээ гадаадад байгаа Монгол хүн бүр Монгол төрийн хайр ивээлийг хүртдэг нөхцөл бололцоог бүрдүүлэх үүрэг даалгаврыг өгсөн. Эдгээр асуудлыг тусгасан Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарна. Энэхүү төлөвлөгөөний дагуу ажил нэлээд эрчимтэй явагдаж байна. Бид хоёр их гүрэнтэйгээ иж бүрэн



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

стратегийн түншлэл хэрэгжүүлэх асуудал дээр онцгой анхаарч ажиллана. Монгол Улсад хөрөнгө оруулах сонирхолтой гадаад иргэдийн итгэлийг сэргээх тал дээр ч ажиллана. Энэ чиглэлээр зохион байгуулсан ажлын үр дүнг, УИХ болон Засгийн газарт тайлагнах болно” гэлээ.

Хилийн чанадад 246 иргэн гэмт хэрэгт холбогджээ

Консулын газрын мэдээлж буйгаар хилийн чанадад түр болон удаан хугацаагаар ажиллаж, амьдарч буй иргэд, мөн хувийн болон албан хэргээр зорчсон монгол иргэд гэмт хэрэг зөрчилд холбогдох, аваар осолд өртөх, эд хөрөнгө, эрүүл мэнд, амь насаараа хохирох явдал гарсаар байгаа аж. Тодруулбал, Хилийн чанадад гэмт хэрэгт холбогдсон буюу ял эдэлж буй монгол иргэдийн тухайд энэ оны нэгдүгээр сарын 1-нээс есдүгээр дүгээр сарын 12-ны байдлаар 246 иргэн гэмт хэрэгт холбогджээ. Мөн өнөөдрийн байдлаар 13 улсад нийт 99 монгол иргэн ял эдэлж байгаа гэнэ. Харин Монголд гэмт хэрэгт холбогдсон буюу ял эдэлж буй гадаад иргэдийн тухайд Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас мэдээллийг нэгтгэсэн байна. Энэ оны есдүгээр сарын 12-ны байдлаар Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын 34 иргэн гэмт хэрэгт холбогдон шалгагдсаны дотор БНХАУ-ын 17, БНСУ-ын зургаа, ОХУ-ын дөрөв, АНУ-ын гурав, Вьетнам, Унгар, ХБНГУ, Израль улсын тус бүр нэг иргэн байгаа ажээ. Түүнчлэн өнөөдрийн байдлаар гадаадын 20 иргэн

баривчлах, цагдан хорих байранд хоригдож байгаа бол долоон улсын 22 иргэн ял эдэлж буй юм байна.

Автобус нь шатсаны улмаас эд зүйлсээ алдсан иргэдийг асуудал юу болов

Бээжин-Замын-Үүд чиглэлд зорчиж байсан автобус шатсантай холбоотойгоор зорчиж явсан 37 монгол иргэний хохирлыг барагдуулах чиглэлээр Гадаад харилцааны яам Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-аар дамжуулан тээвэр гүйцэтгэж байсан “Есөн луу” компанитай тогтмол холбоотой ажиллаж байгаа аж. Дээрх иргэдийн хувьд хохирлоо барагдуулахаар “Есөн луу” компанид өргөдөл гаргаж, галд шатсан эд зүйлсийнхээ үнийн дүнг баталгаажуулж өгөөд байсан бөгөөд үүний дагуу тус компанийг даатгагч компанийн зүгээс эдгээр иргэний хохирлыг бүрэн барагдуулах шийдвэр гаргажээ. “Есөн луу” компанийн зүгээс хохирсон иргэдтэй холбогдож, Эрээн дэх салбараараа дамжуулан нөхөн төлбөр олгож эхэлсэн аж. Одоогийн байдлаар есөн иргэний хохирлыг барагдуулаад байгаа бөгөөд нөхөн төлбөр өгөх ажиллагаа үргэлжилж байгаа гэнэ.

ОХУ–д амиа алдсан иргэдийн цогцсыг олжээ

ОХУ-ын Красноярск хотноо өнгөрсөн наймдугаар сарын 30-ны өдөр Монгол Улсын хоёр иргэн усанд живж амь насаа

алдсан хэрэг гарсан билээ. Тэгвэл энэхүү хэрэг гарсан даруйд буюу есдүгээр сарын 01-нд Гадаад харилцааны яамны зүгээс Эрхүү дэх Ерөнхий консулын газраар дамжуулан ОХУ-ын ГХЯ-ны Красноярск дахь төлөөлөгчийн газарт эрлийн ажлыг шуурхай явуулах хүсэлт тавьсны дагуу нэг иргэний /талиийгаач О/ цогцсыг олсон байна. Харин нөгөө иргэний /талиийгаач Д/ цогцсыг хайх ажиллагаа явагдаж байсан бөгөөд өчигдөр олсон тухай Оросын талаас урьдчилсан байдлаар мэдэгдсэн байна. Талийгаач О-гийн цогцсонд хийсэн задлан шинжилгээний дүгнэлт гарсан бөгөөд ямар нэгэн гадны нөлөөгүй болох нь тогтоогдсон байгаа ажээ.

Амиа алдсан уулчны хэрэгт хоёр хүнийг холбогдуулан шалгаж байна

Хангай нурууны оргилд гарах зорилгоор найзынхаа хамт Монголд ирсэн Их Британийн уулчин бусдад дээрэмдүүлж, амиа алдсан хэрэг гарсан. Тодруулбал, өнгөрсөн наймдугаар сарын 31-ний өдөр Архангай аймгийн Хангай сумын Тэрх багийн нутаг Хандрагат гэх газарт амь насаа алдсан байдалтай олдсон. Цагдаагийн байгууллагаас өгсөн мэдээллээр тээрэр ир, үзүүртэй зүйлээр цээжний хөндийд хатгагдаж нэвтэрсэн шархны улмаас гадна болон дотуур цус алдаж нас барсан байх магадлалтай гэсэн урьдчилсан дүгнэлт гарсан байна. Уг хэргийг Архангай аймгийн Цагдаагийн газар, Улсын Мөрдөн байцаах газрын онц ноцтой хүнд

гэмт хэрэгтэй тэмцэх тасгийн хамтарсан ажлын хэсэг шалгаж байгаа аж. Одоогоор хоёр хүнийг сэжигтнээр саатуулаад байгаа бөгөөд хэргийн газраас олдсон нотлох баримтуудыг шинжилгээнд өгөөд байгаа юм байна. ГХЯ-ны Консулын газрын зүгээс дээрх хэрэгтэй холбоотойгоор ИБУИНВУ-ын ЭСЯ-тай тогтмол холбоотой ажиллаж, ЭСЯ-наас тавьсан хүсэлтийн дагуу талийгаачийн шарилыг эх оронд нь хэрхэн хүргүүлэх болон хэргийг мөрдөн байцаах үйл ажиллагаатай холбоотой шаардлагатай мэдээллийг тогтмол өгч байгаа аж.

БНСУ–д газар хөдлөлтөд Монгол иргэн өртөөгүй гэв

БНСУ-ын Онцгой байдлын газрын энэ сарын 13-ны өдрийн өглөөний 05:00 цагт гаргасан дүгнэлтээс үзвэл Кёнсанд найман хүн, Кёнбүгд тав, Тэгү хотод хоёр, Чоннам аймагт нэг хүн бэртсэн гэнэ. Гэхдээ Монгол иргэн газар хөдлөлтөд өртөж, гэмтээгүй юм байна.

Ийнхүү мэдээлэл хийсний дараа Консулын газрын дарга Я.Ариунболдоос зарим зүйлийг тодруулсан юм.

-Хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээх үүднээс Гадаад харилцааны яам ямар ажил хийх вэ?
-Сүүлийн 3-4 жил гадаадын хөрөнгө оруулагчдын тоо эрс буурсан.Харин энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөрт гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээх, орчноо сайжруулахаар

төлөвлөсөн байгаа. Өнгөрсөн хугацаанд Монгол Канадын Засгийн газар хоорондын хөрөнгө оруулалтын хэлэлцээр олон жил хүлээлттэй байсан. Сая Канад улсын парламентын нийтийн танхимын дарга айлчлах үеэр гарын үсэг зурагдсан. Ер нь бол гадны хөрөнгө оруулалтыг татах хамгийн чухал асуудал бол эрх зүйн орчин болоод хүний нөөц тогтвортой байх явдал юм. Түүнээс татварын хөнгөлөлт чухал биш.

-Өнгөрсөн долоо хоногт цахим ертөнцөөр Монгол Улс давхар иргэншлийг зөвшөөрнө гэсэн утга бүхий мэдээлэл тархсан. Энэ талаар тодруулаач?

-1998 оноос хойш хилийн чанадад 4800 хүүхэд төржээ. Эдгээрийн 2181 хүүхэд давхар иргэншлийн асуудалтай байгаа аж. Тухайлбал эцэг, эх нь АНУ-д оршин суугдийн улмаас Америкт төрсөн хүүхэд автоматаар тухайн улсын иргэншилтэй болдог. Эдгээр хүүхдүүдийг Монгол Улсын иргэнээс хасмааргүй байгаа юм. Тэгэхээр Монгол аав, ээжтэй гадаадад төрсөн монгол хүүхдүүдэд давхар иргэншлийг зөвшөөрөх, олгох асуудал яригдаж байгаа гэдгийг ойлгоорой. Мөн 1990-ээд оны эхээр манай баруун хязгаар оршин суудаг казах иргэд Казахстан улс руу нүүсэн. Гадаадын иргэн харьяатын асуудал эрхэлсэн газрын статистик мэдээллээр Монголын 40 гаруй мянган иргэн Казахстаны харьяат болсон. Монгол Улсынхаа харьяатаас гарч амжаагүй байхад тухайн улсын иргэн болох асуудлаа шийдүүлдэг аяаад байсан учир 90-ээд оны сүүлээр 25 мянган казах иргэн хоёрдмол харьяалалтай байсан. Казахстаны талтай зөвлөлдөх уулзалтыг хийсний үр дүнд дээрх тоог 2700 хүртэл бууруулж чадсан. Үүнээс гадна Казахстан, Монголын зөвлөлдөх уулзалтын үеэр хоёрдмол харьяаллыг арилгах, иргэншлээ солих асуудлыг хөнгөвчлөх асуудлаар хоёр талын хэлэлцээр байгуулахаар болсон.

-Өмнөд Солонгос улсын виз хөнгөвчлөгдсөнтэй холбогдуулан визны хугацаа хэтрэлт нэлээд их байна. Үүнийг хэрхэн зохицуулж байна вэ?

-Солонгос улс руу гарах хүсэлтэй 50 мянган иргэн нэг жилд виз мэдүүлдэг. Үүнийг хариуцан ажиллаж байгаа Солонгосын Элчин сайдын яамнаас мэдээлж буйгаар 95 хувьд нь виз олгосон байгаа юм. Гэтэл өнөөдөр нэг сард дунджаар 360 хүн визны хугацаа хэтрүүлэн үлдэж байна. Энэ нь Солонгос улсад хугацаа хэтрүүлэн үлдэж байгаа буюу харлаж байгаа үзүүлэлтээрээ Монгол Улс тэргүүлж байна гэсэн үг. Үүнээс болоод визны нөхцлийг хөнгөвчлөх асуудал ярвигтай болно. Өөрөөр хэлбэл, зөвхөн өнөөдөр маргаашаа бодож үлдээд байгаа хүмүүсийн нөлөөгөөр виз хөнгөвчлөх нөхцлийг удаан үргэлжлүүлэхэд амаргүй болж байна гэсэн үг юм.

Дугаарын 60 мөр

Хэдхэн паспорт хэвлэх тэнхээтэй байгаач

Дарин дээр давс нэмнэ гэгчээр хурдан, шуурхай үйлчилж чадахгүй байгаатай зэрэгцээд энэ жилийн хувьд өнөөх гадаад паспортыг хэвлэх бэлдэц нь хомсдож, яаралтайгаар захиалах эрхийг хаачихлаа. Гэтэл энэ бүхний цаана хэчнээн иргэд хохирч байгааг хэлж мэдэхгүй юм. Тухайлбал, Монголын иргэн яаралтайгаар гадаад паспортоо захиалаад, гадны аль нэг улс руу аялах зугаалах эрхгүй болоод байна. Тухайн хүн паспортоо захиалаад ажлын 10 хоног буюу амралтын хоногтойгоо нийлээд хэдхэн хоёр долоо хоногийн дараа арай гэж авч байна шүү дээ. Энэ бол амралтаа тааруулаад аялах, гадаадад сурч байгаа хүүхдээ эргээд ирэх хангалттай хугацаа. Харин гадаадад эмнэлэгийн үйлчилгээ авах гэж буй өвчтэй хүн бол аль хэдийн амна алдчихаар хугацаа шүү дээ. Аз болж гадаадад эмнэлгийн үйлчилгээнд хамрагдах, сургуульд сурах, хурал, чуулганд зэрэг яаралтай гадаад улс руу зорчихоор болсон цөөн иргэний асуудлыг арай ядан шийдвэрлэн өгч байгаа юм билээ. Манай улс шиг цөөхөн хүн амтай оронд энэ бол байж болохгүй асуудал. Гурван сая хүн ам нь бүгд гадаад паспорт захиалаад, ачаалал үүсгээд, асуудал болоогүй нь тодорхой. Гэтэл нийгмийн идэвхтэй хэсэг болох хэдхэн мянган хүнд паспорт хэвлээд өгчих ачаалал даах чадваргүй бүхэл бүтэн улсын бүртгэлийн газар байж таарах уу. Тодруулбал, манай улсын бүртгэлийн газарт жилд дунджаар 120 мянган иргэн л гадаад паспорт авах хүсэлтээ гаргадаг байсан. Харин сүүлийн хоёр жилд буюу ОХУ руу визгүй зорчиж эхэлснээс хойш энэ тоо 70 мянгаар

нэмэгдсэн байгаа юм. Энэ оны эхний долоон сарын байдлаар 122 мянган иргэн паспортын захиалга өгөөд байгаар харгалзан төсөвт нэмэлт тодотгол хийлгэж, бэлдцийг нэмж захиалах шаардлага гарсан гэсэн. Учир нь гадаад паспортын бэлдэц нь хомсдоод ирсэн хэрэг. Тиймээс бүртгэлийн газраас өнгөрөгч дөрөвдүгээр сард Сангийн яаманд хүсэлт гаргаж байж, өнгөрсөн сард урьдчилгаагаа арай гэж шийдүүлснээр бэлдцийн захиалга өгсөн байгаа юм. Ийнхүү захиалсан бэлдэц нь энэ сарын сүүлээр ирэхээр болсон тул ирэх аравдугаар сараас эхлэн яаралтай захиалга хэвийн явагдах аж. Манай улс ийнхүү хэдхэн мянган иргэдийнхээ асуудлыг шийдэж чадахгүй барц алдаж байхад, хэдэн тэрбум хүн амтай улс орнууд энэ асуудлаа яаж зохицуулаад болоод байгаа юм бэ. Өнөөдөр техник технологи хурдацтай хөгжиж байгаа энэ цаг үед бидний амьдралд түүнийгээ дагаад олон шинэ дэвшил гарч байгаа. Тиймээс ч улсынхаа бүртгэлийн газрыг цаг үетэй нь хол нийлүүлэн алхуулах шаардлага тулгарч байгаа хэрэг. Хэрвээ улс нь гадаад паспортын бэлдэц авч чадахгүй, төсөв мөнгө нь хүрэлцэхгүй байгаа бол аль нэг санхүүгийн чадвартай хувийн хэвшилээрээ энэ ажлыг гүйцэтгүүлчихэж яагаад болохгүй гэж. Магадгүй хувийн хөвшилнхэн иргэд яаралтайгаар мөнгө төлөөд захиалж л чадаж байвал паспортыгхоногт нь ч гаргаад өгч чадах л байх. Тиймээс энэ мэт жижиг юм шиг хэрнээ олон хүний эрх ашгийг хөндсөн асуудлаа зохицуулаад сурчихмаар юм.



WSJ: ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ХУВЬД “ХАЛУУХАН БҮСГҮЙ” БАЙСАН МОНГОЛ ХАЯГДАЖ ҮЛДЭВ

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Түүний илчлэлт Монголын зах зээлийн валютын ханш огцом унахад ч нөлөөлөв. Өнгөрсөн сард гэхэд төгрөгийн ам.доллартай харьцах ханш 7.7 хувиар унаж, үндэснийх нь мөнгөн тэмдэгт хөгжиж буй орнуудын дундаа хамгийн сул валют болж хувирсан билээ. Гэхдээ Олон улсын санхүүгийн хүрээлэнгийн Ази номхон далайн ахлах эдийн засагч Бежоё Дас Гупта “Саяхныг хүртэл Монголын зах зээл бүрхэг байсан. Тэд буруу зүйл юу ч хийгээгүй. Гэхдээ хэвийн байдалд орохын тулд хүндхэн сорилттой тулгарна” гэж онцолсон. 2011 онд ээс, алт, төмрийн ханш өссөнтэй холбоотойгоор эдийн засгийн өсөлт нь 17 хувьд хүрч, дэлхийн хамгийн хурдацтай өсөлттэй улс болж байлаа. Одоогоор Хөрөнгө оруулагчдын хамгийн гол найдвар нь эдийн засгийн

ч яг адил дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнэ өсч буурахад нэрвэгдсэн” гэж хэлжээ. Харин Монголын засгийн газрын удирдлагууд гадны хөрөнгө оруулалт тэр дундаа Канадын хөрөнгө оруулалтыг хамгаалж, дэмжинэ гэдгээ онцолж байлаа. УИХ-ын дарга М.Энхболд “Эдийн засгийн хямралын эсрэг Монгол улсын засгийн газар иргэдийнхээ нуруунд хүнд ачаа үүрүүлэхгүйгээр эдийн засгийн нөхцөл байдлаа сайжруулахад гадаадын хөрөнгө оруулалт чухал гэж үзэж байгаа” хэмээн өгүүлсэн. Мөн “Тиймээс бид хөрш болон бусад орнуудын үзүүлсэн хөрөнгө оруулалтыг хамгаалах, дэмжихэд онцгой анхаарал хандуулах болно” хэмээн нэмж хэлэв. Үүнээс гадна Монголд хөрөнгө оруулсан гадаадын хөрөнгө оруулагчдын аюулгүй байдлыг хамгаалахад Засгийн газраас тодорхой арга хэмжээг авч ажиллахаа амлаж, хоёр улсын харилцааг

бэлэн байна” гэж нэмж хэлжээ. Зах зээл дэх түүхий эдийн үнийн уналт, Хятадын эдийн засгийн удаашрал, хөрөнгө оруулалтыг хязгаарласан хууль, засаглалын буруу бодлоготой холбоотойгоор хөрөнгө оруулагчид нь дайжсаны улмаас байгалийн арвин их нөөц баялагтай Зүүн Азийн энэ улс хөрөнгө оруулагчдын итгэлийг дахин олохын тулд аргаа барж байна. Уг нь Засгийн газрын албаны их сурвалжийн өгүүлснээр тус улсын эрдэс баялгийн нийт үнэлгээ 1.3 их наяд ам.доллар аж. Өмнөговьд орших Тавантолгойн орд бол гангийн түүхий эд, дэлхийн хамгийн сайн чанарын коксжих нүүрстэй бөгөөд нөөц нь 7.5 тэрбум тонн хэмээн таамагладаг. Гэвч ордын үйл ажиллагааны менежментийг хэн хариуцах нь засаг захиргааны туйлбаргүй хүнд суртлаар тодорхойлогддог нь гол асуудал юм. 2011 онд АНУ-ын уул уурхайн “Peabody energy”, Хятадын Шенхуа болон Орос Монголын концерциумыг үйл ажиллагааны менежмент хийх компаниар тодруулсан боловч, хоёрхон сарын дараа Монголын аюулгүй байдлын зөвлөл цуцалсан шийдвэр гаргасан байдаг. Улмаар өнгөрсөн жил парламент дээр Тавантолгойг гадны концерциумд өгөхгүй хэмээн шийдсэнээр Хятадын “Шенхуа энерги”, Японы Сүмитомо корпораци хонконгийн хөрөнгийн биржид бүртгэлтэй “Mongolian mining Corp”-ийн Тавантолгой дахь сонирхол царцсан. Хэдий тийм боловч дээрх компаниуд Тавантолгойд оролцох сонирхол нь хэвээр байгаагаа илэрхийлдэг юм. Тэгвэл шинээр байгуулагдсан Засгийн газар Тавантолгойн хөрөнгө оруулалтын гэрээг нааштайгаар эргэн үзэж, ордыг түшиглэж Японы Марубенитэй хамтран барих цахилгаан станц болон Хятадын Чалько группт төлөх өр зэрэг асуудлыг шийдэхээр ажиллаж эхэлжээ.

www.moodyс.com:
Зээлжих зэрэглэлийг дахин бууруулж болзошгүй

“Moody’s” хөрөнгө оруулагчдын үйлчилгээний төвөөс Монгол Улсын Засгийн газрын урт хугацааны зээлжих зэрэглэлийг “B2”-оос “B3” болгон бууруулж, ирээдүйн төлвийг “сөрөг” хэмээн үнэлжээ. Үүний зэрэгцээ Засгийн газрын өрийн зэрэглэлийг “B3” болгон бууруулсан бол богино хугацааны зээлжих зэрэглэлд өөрчлөлт оруулалгүй хэвээр үлдээжээ. Тус агентлагийн тайланд дурьдсанаар Монгол Улсын зээлжих зэрэглэл ирэх гурван сард дахин буурах магадлалтай хэмээн үзсэн байна. Монгол улсын Засгийн газрын хямралаас гарах хөтөлбөрийн үр дүн, түүний ДНБ-ий өсөлтөд үзүүлэх нөлөө гадаад өрийн эргэн төлөлтийг дахин санхүүжүүлэх чадвартай болох эсэхээс шалтгаалж зээлжих зэрэглэлийг дахин бууруулах талаар авч үзнэ гэжээ. Гэхдээ тус агентлагаас ирэх 12-18 сарын хугацаанд Монгол Улсын зээлжих зэрэглэл дахин буурах магадлалтай, сөрөг хандлагатай байна хэмээн дүгнэсэн байгаа юм. Он гарсаар хоёр дахь удаа манай зээлжих зэрэглэл буурч байгаа нь энэ. Өнгөрсөн наймдугаар сарын 19-нд олон улсын үнэлгээний “Standard & Poor’s”, “Fitch” зэрэг агентлагууд ч манай улсын урт хугацааны зээлжих зэрэглэлийг “B-” болгон бууруулсан билээ.

www.mining.com:
Хямралаас гарах эхний алхам Тавантолгойг хөдөлгөх

Дэлхийн “mining.com”, “reuters”, “finance.yahoo.com” зэрэг томоохон сайтуудад зургадугаар сард болсон сонгуульд үнэмлэхүй ялалт байгуулсан МАН-ын Засгийн газрын хямралаас гарах эхний алхам нь Тавантолгойн ордыг дахин хөдөлгөх гэдгийг тодотгон бичсэн байлаа. Тус нийтлэлд “Бэлэн мөнгөний гачигдалд орж, улс орон нь дампуурах дээрээ тулаад буй далайд гарцгүй Монгол Улс өвчлөсөн эдийн засгаа сэргээх гаргалгааг хайж, Өмнийн говийн том орд Тавантолгойн уурхайг дахин ашиглахаар ээхэж эхлэв. Үүний эхний алхам болж, Тавантолгойн ордын лицензийг эзэмшигч “Эрдэнэс Тавантолгой” төрийн өмчит компани ордын нөөц, эдийн засгийн үр өгөөжийг тооцож эхэлжээ. “Бид боломжит бүх хувилбарыг тооцож байна” хэмээн “Эрдэнэс Тавантолгой” компанийн эдийн засаг, хөгжил хариуцсан захирал С.Ашидмөнх “Ройтерс” агентлагт ярицлага өгөхдөө хэлсэн бөгөөд “Хэрэв эрдэнэс Тавантолгойд цаашлаад Монголын эдийн засагт өгөөжтэй л бол бид хэнтэй ч хамтран ажиллахад

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ



ᠨᠢᠶᠢᠳᠤ ᠠᠢᠭᠠᠳᠠᠭᠠ ᠳᠠᠢᠭᠠᠳᠤ
ᠳᠠᠢᠭᠠᠭᠠᠳᠠᠭᠠ ᠡᠭ ᠶᠠᠳᠠᠭᠠ ᠠᠢᠭᠠᠳᠠ
ᠨᠥᠳᠡᠭᠡᠭᠡ ᠰᠠᠭᠠᠭᠠᠭᠠ. ᠣᠵᠢᠭᠡᠭᠡ
ᠳᠤᠵᠢᠵᠤᠭᠤᠵᠤᠭᠤᠳᠤ ᠳᠤᠶᠢ ᠳᠣᠭᠠᠠᠢ.
ᠠᠭᠡᠭᠠᠭᠠᠭᠠ ᠡᠭ ᠳᠠᠳᠤᠳᠠᠭᠡ, ᠳᠤᠶᠠᠭᠤᠳᠤᠭᠡ,
ᠳᠣᠭᠡᠳᠣ, ᠳᠠᠭᠡᠳᠠᠠᠢ ᠠᠭᠡᠳᠤ ᠴᠤᠳᠠᠭᠠᠳᠤ
ᠨᠣᠳᠠᠭᠠᠭᠠᠭᠠ. ᠠᠭᠤᠠᠢᠶᠢᠨ ᠠᠭ
ᠳᠤᠵᠢᠶᠡᠭᠡᠭᠡᠭᠡ ᠡᠭ ᠨᠠᠭᠡᠢ ᠢᠭᠡᠳᠠᠭᠡ,
ᠨᠣᠳᠤ ᠠᠶᠠᠨᠠᠢ.

Монгол улсын гавьяат тамирчин
Д.Сумъяа

Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

өсөлтийн ихэнх хувийг бүрдүүлдэг алт, зэсний уурхай болж хувираад байна. 2015 оны арванхоёрдугаар сард тус улсын Засгийн газар Рио Тинто компанитай дөрвөн жил дуншсан Оюутолгойн ордын хоёр дахь хэсэг дэлхийн хамгийн том нөөцтэй далд уурхайн гэрээг үзэглэсэн. Гэвч төсөл амжилттай хэрэгжихэд ханш том саад учруулж байна. Тодруулбал, зэсний үнэ дэлхийн зах зээлд хоёр дахин унасны улмаас улсын санхүүгийн хямрал гүнзгийрч, шинэ Засгийн газар онцгой нөхцөл байдалд ажиллаж байгаа юм” гэсэн байв.

Xinhuanet.com:
Монгол Канадаас хөрөнгө оруулалт татах нь

Тэгвэл манай өмнөд хөршийн төрийн мэдлийн “Синьхуа” агентлагийн цахим хуудаснаа эдийн засгийн хүндхэн сорилттой тулгарч буй манай улс Канадаас хөрөнгө оруулалт татахаар мэрийж, тус улсын спикерийн айлчлалын үеэр ч энэ талаар уг унагаж дөнгөснийг онцолсон байлаа. “Канадын спикер Жеофф Реган хоёр өдрийн хугацаагаар Монголд айлчиллаа. Айлчлалын хүрээнд хоёр улсын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд талууд тохиролцоонд хүрчээ. Айлчлалын үеэр Реган хоёр улсын харилцааг өргөжүүлж, шинэ шатанд гаргахад түүний энэ удаагийн айлчлал чухал ач холбогдолтой гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлсэн. Тэрбээр “Канад, Монгол хоёр улсад нийтлэг талууд маш их. Хоёр улсын эдийн засаг

МОНГОЛЫН МЭДЭЭ

Манай сонины IV улирлын захиалга үргэлжилж байна

Улиралд 64 дугаар

Захиалгын үнэ 18000


Монгол шуудан: 70078977
УБ шуудан: 70127027
Скай пост: 70121294
Түгээмэл шуудан: 70115025

☎

Дэвид Камерон улс төрийг орхилоо

Их Британийн Ерөнхий сайд асан Дэвид Камерон конгрессийн гишүүний албан тушаалаасаа огцорч, улс төрийн ертөнцөөс гарч буйгаа мэдэгдлээ. Тэрбээр энэ шийдвэрээ тайлбарлахдаа Их Британийн шинэ Засгийн газрын үйл ажиллагаанд саад учруулахыг хүсэхгүй байна гэж мэдэгдсэн байна. Мөн парламентын нийтийн танхимын гишүүний хувиар эсэргүүцэж байсан боловсролын системийн шинэтгэлийг сайд нар танхим хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаатай энэ шийдвэр нь холбоогүй гэдгийг онцлон хэлсэн байна. Түүнчлэн Ерөнхий сайд асан Камерон олон нийтийн төлөө хүчин зүтгэж, олон улсын асуудлаарх байр сууриа байнга илэрхийлж байх болно гэдгээ мэдэгджээ. Их Британид Европын холбооноос гарах эсэх талаарх бүх нийтийн санал асуулга болж, иргэдийн ихэнхи нь гарах сонголтыг хийсний дараа ард иргэдээ үлдэх сонголт хийхийг уриалж байсан экс Ерөнхий сайдын хүчин чармайлт талаар болсон. Тэгвэл тэрхүү явдлаас хойш гурван сар хүрэхгүй хугацааны дараа тэрбээр улс төрийн ертөнцөөс “тэтгэвэртээ гарч” байгаа нь энэ юм.

Эдүгээ 49 настай экс Ерөнхий сайд зургадугаар сард болсон санал асуулгын дараа албан тушаалаасаа огцрохоо мэдэгдэж байв. Харин долдугаар сард Тереса Мейд Ерөнхий сайдын суудлаа шилжүүлэн өгсөн байдаг. Дэвид Камерон 2001 оноос хойш Оксфордшир мужийн Уитни тойргоос парламентад сонгогдож байсан юм. Түүний парламентын нийтийн танхимын гишүүний бүрэн эрх 2020 онд дуусах ёстой байсан билээ.



...Орон нутгийн цагаар өчигдөр өглөөний 10.00 цагийн үед Өмнөд Солонгосын нийслэл Сөүл хотоос 65 км-т байрлах цэргийн баазад АНУ-ын стратегийн бөмбөгдөгч B-1B

загварын хоёр онгоц газардсан байна. Онгоцыг хүлээн авах ёслолд БНСУ-ын цэргийн штабын генерал И Сүн Жин, АНУ-аас тус улсад суух АНУ-ын армийн генерал Винсент Брук нар оролцож, хамтарсан хэвлэлийн хурал хийжээ...

Б.ДАВААХҮҮ

БНАСАУ өнгөрсөн долоо хоногт тав дахь цөмийн зэвсгээ туршсан. Орон нутгийн

АНУ

БӨМБӨГДӨГЧ ОНГОЦОО СӨҮЛ РҮҮ ИЛГЭЭВ

эх сурвалжийн мэдэгдсэнээр энэ туршилтаар Пхеньяны цөмийн мэргэжилтнүүд баллистик пуужинд тохирох цөмийн хошууг бий болгож чадсан гэх. Харин эдүгээ дахин цөмийн зэвсэг туршихаар бэлтгэлээ базааж буйг АНУ, БНСУ-ын тагнуулынхан олж мэдсэнээр Солонгосын хойгийн байдал түгшүүртэй болж эхлээд байгаа юм. Тэгвэл өчигдөр АНУ стратегийн бөмбөгдөгч онгоцоо Сөүл рүү илгээжээ. АНУ, БНСУ-ын цэргийн албаны эх сурвалж “Олон улсын нийгэмлэгийг эрээ цээргүйгээр үл тоож буй Пхеньяныг нухчин дарахын тулд цэргийн ажиллагааг бэхжүүлэх шаардлагатай болсон” гэдгийг онцолсон байна. Орон нутгийн цагаар өчигдөр өглөөний 10.00 цагийн үед Өмнөд Солонгосын

нийслэл Сөүл хотоос 65 км-т байрлах цэргийн баазад АНУ-ын стратегийн бөмбөгдөгч B-1B загварын хоёр онгоц газардсан байна. Онгоцыг хүлээн авах ёслолд БНСУ-ын цэргийн штабын генерал И Сүн Жин, АНУ-аас тус улсад суух АНУ-ын армийн генерал Винсент Брук нар оролцож, хамтарсан хэвлэлийн хурал хийжээ.

Хэвлэлийн хурлын үеэр Винсент Брук “АНУ холбоотноо хамгаалах үйлсээс хэзээ ч няцахгүй” хэмээн онцлон тэмдэглэсэн байна. Харин БНСУ-ын цэргийн генерал И олон улсын нийгэмлэгийг үл тоож буй Пхеньяны эсрэг цэргийн үйл ажиллагаагаа чангатгах хэрэгтэй болсныг учирлаж байжээ. Нөгөө талаар, БНСУ-ын Ерөнхийлөгч Пак

Гын Хе өчигдөр өглөө Засгийн газрын албан тушаалтнуудтай хийх уулзалтынхаа үеэр “Хойд Солонгосын ард түмэн өлсгөлөн, ядууралд нэрвэгдэн өдөр хоногийг арайхийн өнгөрүүлж байхад Пхеньяны дэглэм энгийн нэг тэмдэглэлт өдрийг тохиолдуулан салтоттай адил цөмийн зэвсэг бүтээж туршиж байна” гэж хэлжээ. Энэ сарын 9-нд БНАСАУ-ын тусгаар тогтсоны тэмдэглэлт өдөр тохиосон бөгөөд энэ өдөр Пхеньян тав дахь цөмийн туршилтаа гүйцэтгэсэн юм. Түүнчлэн, БНСУ-ын анхны эмэгтэй Ерөнхийлөгч “Өмнөд Солонгосын Засгийн газар болоод цэргийн арми АНУ-тай Батлан хамгаалахын салбарт илүү нягт хамтран ажиллах бөгөөд Пхеньян манай хилийг чиглүүлэн цөмийн хошуугаар

цэнэглэгдсэн нэг л баллистик пуужин харвах юм бол хормын төдийд БНАСАУ-ын дэглэмийг төгсгөл болгоно гэсэн дайны бэлэн байдлаа хадгалах хэрэгтэй”-г сануулжээ. Сөүлд газардсан B-1B нь цөмийн зэвсгээр тоноглох боломжтой стратегийн бөмбөгдөгч онгоц бөгөөд БНАСАУ тав дахь удаагийн цөмийн туршилт хийсэнтэй холбогдуулан Гуам дахь цэргийн баазаас тус улсад иржээ. Үүнээс гадна Японд цэргийн сургуулилтад хэрэглэгдэж буй F2 байлдааны хоёр хөлөг тун удахгүй Солонгосын хойг руу нисэх юм байна. Мөн БНСУ F15 сөнөөгч онгоцоо ч бэлэн байдалд шилжүүлж, БНСУ, Япон, АНУ гэсэн гурван улс батлан хамгаалахын салбарт хамтарч буй ажээ.

Өмнөд Солонгост газар хөдөлжээ

Өмнөд Солонгосын цаг уурын хүрээлэнгээс өчигдөр орой тус улсын өмнөд этгээдэд 5.8 магнитудын хүчтэй газар хөдөлсөн тухай мэдээллээ. Өмнөд Солонгос улсад өмнө нь ийм хэмжээний хүчтэй газар хөдөлж байсан удаагүй аж. Газар хөдлөлтийн голомт Кёнжу хотын ойролцоо байрлаж байжээ. Даваа гарагийн оройн 20.30 цагийн үед нутгийн өмнөд хэсэгт эхэндээ 4.9, 5.4 магнитудын хүчтэй газар хөдлөлт дараалан ажиглагдсаны дараа 5.8 магнитудын хүчтэй газар хөдлөлт болсон байна.

Одоогоор хүний амь эрсэдсэн гэсэн мэдээлэл байхгүй байгаа бөгөөд найман хүн гэмтсэн гэдгийг эх сурвалж өгч байна. Солонгосын хойгт өмнө нь 5.3 магнитудын хүчтэй чичиргээн мэдрэгдэж байсан удаатай. Гэхдээ АНУ-ын Геологийн судалгааны хүрээлэн Хойд Солонгос цөмийн зэвсэг туршсантай холбоотойгоор чичиргээн үүссэнийг онцолсон байдаг. Энэ удаагийн газар хөдлөлт 1978 оноос хойшхи хамгийн хүчтэй газар хөдлөлтөд тооцогдож байна. Байгалийн гамшигт үзэгдлийн улмаас эвдэрч хэмхэрсэн тавилгандaa

дарагдаж гэмтсэн, байшин барилгад ан цавгарсан, усны хоолой хагарсан гэх мэт дуудлага 250 гаруй удаа бүртгэгджээ. Түүнчлэн Кёнжу хотод газар хөдлөх үед гэртээ харилгүй сургуулийн хашаа, олон нийтийн байшин барилга бараадан шөнийг гудамжинд өргөрүүлсэн хүмүүс ч олон байсан гэнэ. Тус улсын цаг уурын хүрээлэнгээс цаашдаа зургаагаас дээш магнитудын хүчтэй газар хөдөлж магадгүй тул анхаарал болгоомжоо дээшлүүлэхийг нийт иргэддээ анхааруулжээ.

ОХУ-ын “цусан гол”-ын учир тайлагдлаа

ОХУ-ын хойд хэсгийн Норильскийн орчмоор урсдаг Далдикан гол цусан улаан өнгөөр урссан тухай бид өмнө нь мэдээлсэн. Улмаар тус улсын Байгаль орчны яамнаас тусгайлан голын өнгө чухам юуны учраас хувирсанд анхаарал хандуулж шинжилж байгаа гэдгээ өнгөрсөн долоо хоногт мэдэгдээд байсан юм. Тэгвэл голын улаан өнгөний учир олджээ.

Албаныхны таамаглаж байсны дагуу гол тухайн бүсэд байрлах Норильский Никель үйлдвэрээс улаан өнгийн бодис гол руу урсаж бохирдуулсан байжээ. Тус компани ч мөн хүлээн зөвшөөрсөн байна.

Никель болон палладин үйлдвэрлэлээрээ дэлхийд тэргүүлэгч Норильский Никель үйлдвэр өчигдөр хийсэн мэдэгдэлдээ энэ сарын 5-нд усархаг бороо орох үед үйлдвэрийн филтерийн сав усаар хальж, гол руу урссан гэдгийг баталсан байна. Мөн хүн болон амьтанд ямар нэг аюул учруулахгүй гэжээ.



Доналд Трамп цагаан ордоны хажууд нүүж очжээ

АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд Бүгд найрамдах намаас нэр дэвшиж буй үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Дональд Трамп Вашингтон хотод цагаан ордоны ойролцоо тансаг зэрэглэлийн зочид буудал нээжээ. Гэвч, зочид буудлын нээлтийн ёслолоос эхлээд л уг үйлдэлд эгдүүцсэн иргэд эсэргүүцлийн жагсаал хийж эхэлсэн байна. Цагаан ордноос холгүй оршдог, XIX зууны үед

баригдсан шуудангийн газрын байрыг Д.Трамп шинэчлэн засварлаж, тансаг зэрэглэлийн зочид буудал болгосон байна. Тус зочид буудлыг “Trump International Hotel” гэж нэрлэсэн бөгөөд товлосон хугацаанаас бараг хоёр жилийн өмнө нээжээ. Зочид буудлын менежерүүдийн ярьснаар, оргил үедээ өрөөний үнэ нэг хоноход 900-25 000 долларын үнэтэй байх бөгөөд нээсэн шөнөөс эхлэн захиалгад дарагджээ.

Латин америкчууд болон лалын шашинтнуудыг ялгаварлан гадуурхсан агуулга бүхий мэдэгдэл хийсэнтэй нь холбогдуулан Д.Трампыг эсэргүүцэгчид тус зочид буудлын гадаа жагсаал хийсэн байна. Уг жагсаалд оролцсон нэгэн эмэгтэй “ийм зочид буудал нийслэл хотод байх нь зохимжгүй. Нийслэл хот бол америкчууд бидний үнэт зүйлсийг тусгаж байх ёстой газар” гэж ярьжээ.



Родриго Дютерт АНУ-д сануулга өгөв

Филиппиний “шийтгэгч” хочит Родриго Дютерт тус улсын өмнөд хэсэгт лалын хэт даврагч бүлэглэлтэй тэмцэж буй АНУ-ын тусгайгийн алба хаагчдыг нутаг буцах ёстойг хэмээн мэдэгджээ. АНУ-ын цэргийн алба хаагчид тухайн хэсэгт байрлаж, орон нутгийн цэргийн алба хаагчдад дэмжлэг үзүүлдэг байна. Родриго долоо хоногийн өмнө АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обамаг “биеэ үнэлэгчийн хүү” гэх зүй бус үгээр доромжилсон удаатай.

Үүний улмаас нэгдсэн улсын төрийн тэргүүн түүнтэй хоёр талт уулзалт хийхээр татгалзаж байсан юм. Филиппиний өмнө этгээдийн Миндонао аралд тус улсын цэргийн бэлтгэл сургуулилтад дэмжлэг үзүүлэх зорилгоор АНУ-ын тусгайгийн бие бүрэлдэхүүн ажилладаг аж. Тэгвэл “шийтгэгч” Ерөнхийлөгч энэ удаа өөрийн батлан хамгаалахын хүчээр хэт даврагчидтай тэмцэхээ илэрхийлж, АНУ-ын цэргийг тус дайнаас гарахыг сануулжээ. 2014 оноос 500-600 америк цэрэг Филиппиний Миндонао аралд үүрэг гүйцэтгэх болсон байдаг. Тухайн үед тус улсын Батлан хамгаалахын сайд Вольтаире Газмин АНУ-ын цэргийн тоог 200-аар багасгах санал гаргаж байсан удаатай. Родриго Дютерт хэчнээн цэргийг, хэзээ нутаг буцах талаар тодорхой мэдээлэл өгөөгүй ч, Филиппин АНУ-тай хамтран ажиллаж буй нь хэт даврагчидтай хийх дайныг улам өдөөж буйг онцолсон байна. Харин АНУ-ын Батлан хамгаалах яамнаас цэргийн алба хаагчдыг буцаан татах асуудлаар Филиппинээс ямар нэг мэдээ ирээгүйг байгааг тодотгожээ.

Си Зиньпиний ойрын хүнийг огцруулсаа

Хятадын Хөдөлмөрийн нам тус улсын дарга Си Зиньпинтэй ойр харилцаатай гэгддэг Тянжин хотын даргыг хууль зөрчсөн гэх шалтгаанаар огцруулсан талаар мэдээллээ. Тянжин хотын захирагч Хуан Сингог Коммунист намын Сахилгын төв комисс ноцтой хууль тогтоомж зөрчсөнтэй холбоотойгоор ийнхүү албан тушаалаас нь огцруулсан гэдгийг орон нутгийн мэдээллийн сайтууд дамжуулж байна. Үүнээс тодорхой зүйлийг намын зүгээс хараахан мэдээлээгүй ч, зарим эх сурвалж хэд хэдэн хувилбарыг дэвшүүлээд байгаа юм. Тодруулбал, Хуан Сингог авлигын хэрэгтэй холбогдуулан баривчилсан байж болох аж. Харин нөгөө нэг хувилбар нь өнгөрсөн жилийн наймдугаар сард Тянжинд болсон томоохон хэмжээний дэлбэрэлттэй холбоотой хэмээн таамаглаж буй юм байна. Хуан Синго Си Зиньпинийг Хэжэн мужид ажиллаж байх үеэс танилцан нөхөрлөх болжээ. Авлигын хэрэгтэй хатуу тэмцэж буй Си Зиньпин Коммунист намын гишүүд, засаг захиргааны томоохон албан тушаалтнуудыг ч ялгалгүй шийтгэл ногдуулж байгаа. Тэгвэл зарим ажиглагчдын тэмдэглэснээр энэ удаа Си Зиньпиний ойрын хүнийг албан тушаалаас нь огцруулсан нь ирэх жилийн намын их хурлаар Коммунист намын дарга солигдож магадгүй гэх таамгийг үүсгэж буй аж.

ЭДИЙН ЗАСАГ

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

...Манайх 6000 орчим ажилтантай. Өнгөрсөн гурван жилийн хугацаанд хэмнэлтийн бодлого баримтлахдаа цомхотгол хийхгүй, ажилчдынхаа цалинг бууруулахгүй гэдэг үндсэн зорилт дор хэмнэлтийн бодлогоо хэрэгжүүлж байгаа...

Ц.Даваацэрэн:
“ЭРДЭНЭТ” ҮЙЛДВЭРИЙН ХУВЬЦААГ ХЭРХЭН ХУДАЛДСАН
ТУХАЙ УИХ-Д ТАНИЛЦУУЛАХ БАЙХ

Төгсгөл.
Түрүүч нь I нүүрт

“Эрдэнэт” ганц Орхон аймгийг гэлтгүй Монгол Улсыг тэжээдэг томоохон үйлдвэр. Оросын тал өөрийн эзэмшдэг 49 хувийг зарснаар үйл ажиллагаа доголдох, олборлогтбагасах, цомхотгол хийх гэх мэт бүтцийн болон үйлдвэрлэлийн өөрчлөлтүүд гарах уу?

Тийм зүйл байхгүй. Хувьцаа эзэмшигч Орос хүн байна уу, Монгол хүн байна уу бидэнд хамаагүй. Бид бол үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа хариуцаж байгаа гүйцэтгэх удирдлагууд. Тиймээс 49 хувийг Орос эзэмшиж байвал бидингэжажиллана, Монголхүн эзэмшвэл ингэж ажиллана гэсэн бодлого байж болохгүй шүү дээ. “Эрдэнэт” үйлдвэр өмнөө тавьсан зорилгоо биелүүлээд, ажилчдынхаа цалин, улсад өгдөг татвараа цагт нь төлөөд, төлөвлөгөөгөө биелүүлээд ажиллаж байх ёстой. Үндсэндээ хувьцаа эзэмшигчдийн асуудал бидэнд хамаагүй. Ер нь хувьцаа борлуулах, бонд босгох эдийн засгийн олон аргууд байдаг. Энэ чиглэл рүүгээ явах байх гэж бодож байна. “Эрдэнэт” үйлдвэр 30-аад жилийн нөөцтэй. 30 жилийн нөөцтэй гэж байгаа ч техник технологийн бодлогыг

зөв хэрэгжүүлэхгүй бол 30 жил ажиллаа ч уу, үгүй ч үү. Тиймээс зөв төлөвлөж, эдийн засгаа харах ёстой. Одоо 37 жил ажиллачихсан үйлдвэрийн хувьд техник технологи үндсэндээ хуучирчихсан. Доорх байгууламжууд ч хуучирч, элэгдлээ. Тиймээс цаашдаа шат дараатайгаар хөрөнгө оруулалт хийх, техник технологиудаа шинэчлэх зайлшгүй шаардлага байна.

-Сүүлийн жилүүдэд уул уурхайн бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээл дээр зогсолтгүй уналаа. Зэсийн үнэ ч хамгийн доод хэмжээндээ хүрсэн талаар салбарынхан хэлдэг. Яг одоогийн байдлаар “Эрдэнэт” үйлдвэрийн үйл ажиллагаа хэрхэн явж байна вэ. Бүтээгдэхүүний үнийн уналт хэрхэн нөлөөлсөн бэ?

-2014 оноос хойш дэлхийн зах зээл дээр зэсийн үнэ уналаа. Гэхдээ энэ хүнд байдлыг бид хэмнэлтийн бодлогын хүчээр давж байна. 2016 оны эхний хагас жилийн байдлаар зэсийн үнэ хамгийн доод төвшинд хүрсэн. 2016 оны нэг, хоёрдугаар сард 4800 ам.доллар болтлоо унасан. Энэ үе бид хэмнэлтийн бодлогоор ажиллаж, эхний хагас жилийн байдлаар 30 орчим тэрбум төгрөгийн ашигтай ажилласан. Одоо ч гэсэн байдал сайжраагүй байна. 2016

оны дөрөв, 2017 оны нэгдүгээр улиралд зэсийн үнэ унах магадлалтай гэсэн мэдээллийг судалгааны байгууллагууд өгч байна. Хэмнэлтийн бодлого гэхээр цомхотгол хийж, ажилчдынхаа цалинг хасаагүй. Харин боломжтой хэмнэж болох зардлуудаа багасгасан. Манайх 6000 орчим ажилтантай. Өнгөрсөн гурван жилийн хугацаанд хэмнэлтийн бодлого баримтлахдаа цомхотгол хийхгүй, ажилчдынхаа цалинг бууруулахгүй гэдэг үндсэн зорилт дор хэмнэлтийн бодлогоо хэрэгжүүлж байгаа. Гурван жилийн өмнө намайг ажил явч байхад нэг тонн цэвэр зэсийг үйлдвэрлэх ханш нь 6600 ам.доллар байсан бол өнөөдөр 4023 ам.доллар болж буурсан. Нэг тонн цэвэр зэс боловсруулах өртгийг 2670 ам.доллараар буулгана гэдэг үйгагүй хөдөлмөр, том амжилт юм.

-Цаашдаа эдийн засаг бүр хүндэрнэ гэдгийг Засгийн газар ч, эдийн засагчид ч хэлж байгаа. Төсвийн орлогын дийлэнх хувийг дангаараа бүрдүүлдэг “Эрдэнэт” үйлдвэр эдийн засгийн хүнд үед үйл ажиллагаа нь хэвийн ажиллаж чадах уу?

-Хямарлын эсрэг хэрэгжүүлэх төлөвлөгөө гэж бий. Энэ төлөвлөгөөнийхөө дагуу л

ажиллана. Зэсийн үнэ доошоо буух тусам бүсээ чангалах бодлого явуулж байгаа. Гэхдээ л бид цомхотгол хийхгүй, ажилчдынхаа цалинг бууруулахгүй байх бодлого барина.

-Засгийн газар хэмнэлтийн горимоор ажиллах үүднээс төрийн өмчит компаниудын удирдлагуудын цалинг бууруулах шийдвэр гарсан. “Эрдэнэт” үйлдвэрийн дарга нарын цалинг ч бууруулна гэсэн үг. Үүнийг хэрхэн хүлээж авч байна вэ?

-Би өөрөө өөртөө цалин тогтоож авдаггүй. Миний цалин хөлсийг “Эрдэнэт” үйлдвэрийн Удирдах зөвлөлөөс тогтоодог. Түүнээс би өөртөө дураараа цалин тогтоогоод, удирдлагуудаа өндөр цалин өгнө гэсэн асуудал байхгүй.

“Эрдэнэт” үйлдвэрийн ТҮЗ хэдэн хүний бүрэлдэхүүнтэй, хэдий хэмжээний цалинтай вэ?

-Төлөөлөн удирдах зөвлөл одоогоор байгуулагдаагүй байна. Өмнө нь яамдын Төрийн нарийн бичгийн дарга нар томилогддог байсан учраас Төрийн нарийн бичгийн дарга нарын томилоог хүлээж байгаа болов уу.

-Дөрвөн жилийн сонгуулийн циклээр монголчуудын амьдрал өрнөж өөрчлөгдөж

байна гэж олон хүн шүүмжилдэг. Уул уурхайн салбарт улстөрийн тогтворгүй байдал, төрийн залгамж чанаргүй байдал хэрхэн нөлөөлж байна вэ?

-Уул уурхайн салбар улс төрийн хэлмэгдүүлэлтэд өртсөн салбар болоод байна. Жишээлбэл, Тавантолгойгоос Гашуун Сухайт хүртэл төмөр замыг 10 гаруй жил ярьж байгаа хэрнээ нэг ч км тависангүй. Үүнээс болж “Тавантолгой”-н нүүрсний борлуулалтын асуудал хүнд байдалд орсон. Үндсэндээ сорчлох маягаар олборлож, коксжих нүүрсийг экспортлож байна. Цаана нь бага калортой эрчим хүчний нүүрсийг ашиглаж, борлуулж чадахгүй өдийг хүрлээ. Хэрэв төмөр зам тавьчихсан байсан бол өнөөдөр чанартай нүүрснээс эхлээд, чанаргүй хүртэл нь борлуулж мөнгө олох боломж байсан. Гэтэл одоо чанаргүй нүүрснүүд байгальд хог болоод хэвтэж байна гэдэг дэндүү хамарсалтай. Тавантолгойн төмөр зам бол улс төрчдийн фракци, нам, эвслийн хоорондын зөрчлөөс болж зогссон. Мөн Тавантолгойн цахилгаан станцыг барьсангүй. Хэрэв цахилгаан станц барьсан бол тэр хог болоод хэвтэж байгаа нүүрсээр цахилгаан үйлдвэрлээд эргэлтэнд оруулах байлаа. Дэлхийн зах зээл дээр

коксжих нүүрс 190 ам.долларт хүрч байхад Тавантолгойн коксжих нүүрсийг 30 ам.доллараар зарж байна. Энэ бол улс төрийн бодлогын алдаа. Мөн Урт нэртэй хууль батлаад байгаль орчноо хамгаалж чадаагүй. Тэр хэмжээгээр нинжа нар нэмэгдэж, нөхөн сэргээх эзэнгүй газар нэмэгдсэн. Нэг гишүүн гарч ирээд нэг хууль санаачлаад, батлуулчихдаг. Тухайлбал, Өсөн нэмэгдэх роялтийн тухай хууль баталсан. Энэ хуулиар 68 хувийн татвар авч эхэлсэн. Гэтэл энэ хууль хэрэгжиж эхэлснээр алтны үйлдвэрүүд дампуурч, олон компани хүнд байдалд орсон. Нөгөө талаар Монгол Улс маш их алтыг үнэгүй алдсан. Тухайлбал, 2006 онд Төвбанкинд 26 тонн алт тушаагдаж байсан бол 68 хувийн татвар авч эхэлснээр 2009 онд зургаан тонн болж буурсан. Яагаад гэвэл нинжа нарын олборлолт зогсоогүй, тэдний гаргасан 5-6 тонн алт Монголд шингээгүй юм. Өнгөрсөн жил алтны татварыг хоёр хувь болгож бууруулахад Монголбанкинд тушаагдаж байгаа алтны хэмжээ 10 тонн хүрээд байна. Энэ мэтчилэн тооцоо судалгаагүй, амьдралд нийцэхгүй хууль эрх зүйн зохицуулалт маш их сөрөг нөлөө үзүүлдэг.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Ё.МАНЛАЙБАЯР: ДАМЖИН ӨНГӨРӨХ ТРАНЗИТ ТЭЭВЭР 90 САЯ
ТОННД ХҮРВЭЛ ДАХИАД НЭГ “ОЮУТОЛГОЙ”-ТОЙ БОЛНО



Гэрэл зургийг Г.АРИУУЖИН

Төгсгөл.
Түрүүч нь I нүүрт

Түүнчлэн энэ удаагийн зөвлөлдөх уулзалт гурван улсыг дамнасан төмөр замын тээврийн коридорыг хөгжүүлэхэд хөрөнгө оруулж хамтран ажиллах сонирхол бүхий гурван талын хувийн хэвшлийн томоохон компаниудын төлөөллийг урьж, саналыг нь сонсож буйгаараа онцлогтой аж. Тухайлбал, Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын төслийн концессын хэлбэрээр хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа Нортерн рейлвейс компани, Замын Үүд-Эрэний хилийн боомтод

хийн түлш шилжүүлэн ачих байгууламж барьж, хий дамжуулан тээвэрлэх сонирхол бүхий оросын “Сибур” зэрэг компани оролцов. Тус зөвлөлдөх уулзалтаар

хэлэлцэж тохиролцсон баримт бичгийн төслүүдийг 2016 оны аравдугаар сарын 20-нд гурван талын тээврийн дээд сайд нар Улаанбаатар хотод уулзах үеэр газрын үсэг зуран албажуулах юм байна. Уулзалтын үеэр Зам тээвэр хөгжлийн сайдын зөвлөх Ё.Манлайбаяртай уулзаж, ярилцлаа.

“Эдийн засгийн коридор” байгуулах хөтөлбөрийн хүрээнд гурван улсын уулзалт хийж байна. Энэхүү уулзалтын хүрээнд ямар хийгдэх вэ?

“Эдийн засгийн коридор”-ын хөтөлбөрт Эрдэнэтээс ОХУ руу холбох, Монголын зүүн болон баруун хэсгээр шинэ төмөр зам бий болгох, зүүн хэсгээс цаашаа БНХАУ-ын нутгаар дамжиж ОХУ-ын алс, дорнодын боомтууд руу холбох, “Москва-Бээжин” чиглэлийн хурдны төмөр замыг Монголын нутгаар дамжуулан тавих зэрэг зэрэг 8 коридорын асуудал бий.

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Засгийн газрын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрт “Эрдэнэт-Овоот”, “Улаанбаатар хотыг тойрсон Богдхан төмөр зам”, “Хөт-Бичигт” чиглэлийн төмөр замыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. “Эдийн засгийн коридор”-ын хөтөлбөрт багтсан зарим төслүүдэд судалгаа хийх, ТЭЗҮ боловсруулах

шаардлагатай байгаа. Мөн бүх юм нь бэлэн болсон төслүүд ч бий.

-Төслийн санхүүжилтыг хэрхэн шийдвэрлэх вэ?

-Төслүүдийг Засгийн газар, хувийн хэвшил эсхүл концессийн гэрээгээр санхүүжүүлж болно гэж заасан. Нөгөө талаасаа эхний ээлжинд санхүүжүүлэх бололцоотой банк, санхүүгийн байгууллагуудыг тодорхойлсон. Тухайлбал, Азийн дэд бүтцийн хөгжлийн банк, БРИКС-ийн банк, “Silk road fund”, шинээр байгуулагдаж буй Шанхайн хамтын ажиллагааны банк зэргээс эхний удаа санхүүжүүлэлт босгохыг хичээнэ. Санхүүжилтын хүрээнд зарим газруудтай тодорхой уулзалт хийж эхэлсэн. Хэрэгжүүлэх төслөө өнөөдөр тодорхойлж банк, санхүүгийн байгууллагуудад хандах юм.

-Эдийн засгийн коридорыг хөгжүүлэх нь ямар ач холбогдолтой вэ. Манай улсад ямар боломжууд нээгдэх вэ?


-Эдийн засгийн коридорыг хөгжүүлснээр манай улсаар дамжин өнгөрөх тээврийг нэмэгдүүлэх өндөр ач холбогдолтой. Дамжин өнгөрөх тээвэр нь хэд хэдэн давуу талтай. Хэрвээ Улаанбаатар төмөр замаар явж буй транзит тээврийн хэмжээ 10 сая тоннд хүрвэл орлого хоёр дахин нэмэгдэх юм. Монгол Улсаар дамжин өнгөрөх транзит 40 сая

тоннд хүрвэл бид дахиад нэг “Эрдэнэт”-тэй болно. Цаашлаад 90 саяд хүрвэл бид дахиад нэг “Оюутолгой”-той болох боломжтой гэсэн үг. Гэхдээ бид хүний ачааг тээвэрлэж өгөөд “Эрдэнэт”, “Оюутолгой”-н хэмжээний орлого олох юм. Энэ нь эдийн засгийн шинэ салбар болох олон урсгалтай бодлогын нэг хэсэг. Зөвхөн уул уурхай бус тээврээр ийм их хэмжээний орлого олох боломжтойг харуулж байгаа юм. Монгол Улс бол хоёр хөрш гүрнийг холбосон хамгийн дөт зам. Бид газарзүйн байршлаа ашиглаад их хэмжээний орлого олох боломжтой. Үүнийгээ хөгжүүлж, хөрөнгө оруулалтын шинэ коридор байгуулах талаар ярьж байгаа юм.

-Замын-Үүдээс Алтанбулаг хүртэлх төмөр замыг хоёр шугамтай болгох асуудал ярьж байгаа. Энэ талаар мэдээлэл өгөхгүй юу?

-Эдийн засгийн коридорын хөтөлбөрт “Төв шугамыг давхар болгож цахилгаанжуулах” тухай орсон. Энэ асуудлыг бид судлах шаардлагатай. Давхар болгох санал 1970-аад оноос явж байсан. Гол нь юу ачих вэ, эдийн засгийн үндэслэл нь хаана байгаа вэ гэдэг дээр бий. Бид хойд Аспайр руу, цаашаа Кизил рүү холбогдсоноор Аспайраас 10 сая тонн, Кизилээс 20-30 сая тонн ачаа шинээр нэмэх юм. Энэ нь хоёр дахь төмөр замыг барих эдийн засгийн үндэслэл болно. Ер нь яригдаж буй коридорууд бүгд дундаа уялдаа холбоотой.

ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА



Гэра зурвиге Г.АГТУУЖИН

Хүссэн хичээлээ сонгож чадаагүй хүүхдүүд

Н.БАТЗАЯА


Багш нь хичээлээ тогъшиг давтаж, сурагчид нь үг дуугүй бичиж суудаг цаг үе хэдийнэ ард үлдэж, манай улсын боловсролын салбарт хөгжлийн салхи сэвэлзэж эхлээд гурав дахь жилтэйгээ золголоо. Тодруулбал, Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт эх оронч сэтгэлгээтэй, амьдрах ухаанд суралцсан иргэн төлөвшүүлэхэд чиглэсэн “Зөв монгол хүүхэд” хөтөлбөр боловсруулж, хөтөлбөрийн хүрээнд цэцэрлэг, сургуулийн насны хүүхдүүдийг монгол бахархалтай, үндэсний соёл, уламжлалыг дээдэлсэн иргэн болгон хүмүүжих нөхцөлийг агуулсан сургалтын стандарттай болох тухай зорилт багтсан байдаг. Энэхүү зорилтынхүрээнд2013ондбага боловсролын цөм хөтөлбөрийг боловсруулан амжилттай хэрэгжүүлсэн. Үүний дараа 2014-2015 оны хичээлийн жилд бага боловсролын шинэчилсэн хөтөлбөрийг үндэсний хэмжээнд эхлүүлсэн юм.

Тус хөтөлбөр амжилттай хэрэгжсэн тул дараагийн үе шатанд шилжин улмаар суурь боловсролын шинэчлэлүүд хийгдэж эхэлсэн. Өөрөөр хэлбэл, цөм хөтөлбөр сургуулийн бүх л шатанд хэрэгжиж эхэлсэн гэсэн үг. Тэгвэл суурь боловсролын шинэчлэлийн хөтөлбөрийг боловсруулж, 2015-2016 оны хичээлийн жилд үндэсний хэмжээнд хэрэгжүүлж эхлээд байгаа юм. Ингэснээр ахлах ангийн сурагчдын судлах хичээлийн тоо багасч, суурь хичээлийг заавал судлахаас гадна өөрийн сонирхсон хичээлийг сонгон судлах боломж нээгдсэн. Тиймээс энэ удаагийн дугаарын сурвалжлагаараа “Ахлах сургуулийн сургалтын цөм хөтөлбөр”-ийн туршилтын талаар хөндөн бэлтгэлээ.

Олонхын зарчмыг сурагчдын хичээл сонголтод хэрэгжүүлж байна

“Ахлах сургуулийн сургалтын цөм хөтөлбөр”-т саашаалтай зүйл олон бий. Тухайлбал, тус хөтөлбөр хэрэгжсэнээр хүүхэд ямар хичээл сонгож суралцахаа өөрөө шийдэх эрхтэй болж байгаа. Өөрөөр хэлбэл, хүүхдийн хүсэл сонирхлыг нэгдүгээрт тавьж байна гэсэн үг...

хичээл сонгож суралцахаа өөрөө шийдэх эрхтэй болж байгаа. Өөрөөр хэлбэл, хүүхдийн хүсэл сонирхлыг нэгдүгээрт тавьж байна гэсэн үг. Ингэснээр тухайн хүүхдийн ирээдүйд эзэмших мэргэжил илүү тодорхой болж, цаашлаад элсэлтийн ерөнхий шалгалтын оноогоо хараад ямар ч хамаагүй мэргэжил сонгодог хүүхдүүд багасч, улс орны хөгжилд хэрэгтэй эрэлт хэрэгцээтэй мэргэжлээр суралцагсад олширч болох талтай. Энэ мэтчилэн дурьдаад байвал олон зүйл бий. Гэвч тус хөтөлбөрийн хэрэгжилтийг тойрсон олон асуудал байгаа нь сурвалжлага хийх явцад харагдаж байлаа. Манай сонины сурвалжлах хэсгийн очсон эхний сургууль бол Ататуркийн нэрэмжит V дугаар сургууль. Тус сургуулийн X дугаар ангид 50, XI дүгээр ангид 210, XII дугаар ангид 181 хүүхэд суралцдаг байна. Бид юун түрүүнд сургуулийн удирдлагатай уулзаж, мэдээлэл авахыг хүссэнгүй. Харин сурагчидтай уулзан “Ахлах сургуулийн сургалтын цөм хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн талаарх бодит мэдээллийг авахыг хүссэн юм. Бидний уулзсан эхний сурагч бол А.Халиун. Тэрбээр V дугаар сургуулийн 12д бүлэгт сурдаг бөгөөд ахлах ангийн туршилтын цөм хөтөлбөрийн тухай ярихдаа “Хичээл хасагдсан нь таалагдаж байгаа. Гэхдээ нэг их хичээл хасаагүй. Гурван хичээл л хасагдсан байна билээ. Хичээл сонгох тал дээр учир дутагдалтай талууд бий. Жишээлбэл, Манай анги 35 хүүхэдтэй. 21 хүүхэд нь нийгмийн ухааны хичээлийг сонгосон юм. Тэгэхээр олонхыг дагаад үлдсэн хүүхдүүд нь ч гэсэн нийгэм судалж байгаа юм л даа. Яах вэ, өөрийнхөө сонгосон хичээлээрээ суралцвал үр бүтээлтэй. Олонхыг дагана гэхээр бидэнд ямар ч ашиггүй. Хэрвээ ингэх бол бараг хичээл сонгохгүй байсан нь дээр” гэсэн юм. Үүний дараа бид 126 ангийн сурагч Г.Номинтой уулзахад бас адил хариулт өгч байв. Г.Номингийн анги нийт 38 хүүхэдтэй бөгөөд ангийнх нь ихэнх хүүхэд физикийн хичээлийг сонгон судалсан учраас мөн л олонхыг дагаж байгаа аж. Сурагчидтай ярилцаж, нөхцөл байдлын талаарх мэдээлэл авсны дараа тус сургуулийн ахлах



...“Ахлах сургуулийн сургалтын цөм хөтөлбөр”-т саашаалтай зүйл олон бий. Тухайлбал, тус хөтөлбөр хэрэгжсэнээр хүүхэд ямар хичээл сонгож суралцахаа өөрөө шийдэх эрхтэй болж байгаа. Өөрөөр хэлбэл, хүүхдийн хүсэл сонирхлыг нэгдүгээрт тавьж байна гэсэн үг...

анги хариуцсан мэргэжилтэн П.Баттогтохтой ярилцлаа. Тэрбээр “Манай сургууль олонхыг дагасан зарчмыг барьж байгаа. Ерөнхийдөө бидэнд 40 хүүхдийг олон хуваах боломж байхгүй. Анги танхимаас гадна төсөв мөнгөний хүрэлцээний асуудал бий. Энэ чинь өмнө нь баталсан төсөв мөнгөн дээр



явж байгаа. Ямар төсвийн тодотгол хийсний дараа гарч байгаа биш. Тэгээд ч одоохондоо шинэ, туршилтын шатандаа явж байна. Цаашид төвлөрсөн ахлах сургууль байгуулаад ирэхээр нэг анги болгох байх. Одоо тав, арван хүүхэд гэрийн багш шиг заагаад байх боломжгүй. Тэрийг хүүхдүүд ойлгох хэрэгтэй” гэдэг хариултыг өгсөн юм. Ийнхүү тус сургуулийн мэргэжилтэнтэй ярилцсаны дараа манай сонины сурвалжлах хэсэг Чингэлтэй дүүргийн 50 дугаар сургуулийг зорив. 50 дугаар сургуульд байдал арай өөр байх аж.

Биднийг очих үед бага ангийн сурагчдын хичээлийн цаг дөхсөн тул хүүхдүүд гаднаа жагсаж байлаа. Харин ахлах сурагчдынхичээлтарсанхэдий ч сонгон судалсан хичээлдээ суух сурагчид сургууль дээрээ байж таарав. Өөрийн дуртай хичээлийг сонгон суралцаж байгаа нь наад таалагдаж байна хэмээн ярих охиныг н.Болор-Эрдэнэ гэдэг. Тэрбээр энэ жил төгсөх ангийн сурагч гэнэ. Анги нь нийт 35 хүүхэдтэй бөгөөд сонгоны хичээл ороход анги танхим хүрэлцээтэй байдаг талаар бидэнд ярив. Мөн тус сургууль хэрвээ нэг ангиас цөөн хүүхэд

ямар нэг хичээл сонговол нөгөө ангийн хүүхдүүдтэй нь хамт хичээллүүлж байгаа аж. Тухайлбал, 35 хүүхэдтэй анги байлаа гэж бодъё. Тэдний таван хүүхэд нь нийгэм, бусад нь физикийн хичээлийг сонгон судлахаар болсон тохиолдолд нийгэм сонгосон таван хүүхдийг өөр ангийн сурагчидтай хамт сонгосон хичээлийг нь судлуулж байгаа ажээ. Харин тус сургуулийн 12г ангийн сурагч н.Золбоо туршилтын хөтөлбөрийн талаар өөр бодолтой явдаг байна. н.Золбоо газарзүйн хичээлийг гүнзгийрүүлж судлахаар сонгон судлахаар болжээ. Гэвч түүний сонгосон газарзүйн хичээлийн сонгон нь 03:00 цагт ордог гэнэ. Тэрнээс болж хичээл нь эрт тарсан тохиолдолд газарзүйн сонгондоо суухын тулд сургууль дээрээ хүлээх шаардлага гардаг байна. Энэ мэтчилэн сурагчдын дунд жижиг гэлтгүй асуудлууд хөвөрсөөр байлаа. Ингээд бид тус сургуулийн захирал Р.Даваахүү, ахлах анги хариуцсан сургалтын менежер н.Бэхбаттай уулзаж цөм хөтөлбөрийн талаар мэдээлэл авах гэсэн ч “Завгүй байна” гэдэг хариултыг өгсөн тул дараагийн сургууль руу яаравчлав.

Гурван сайдын тушаал бүлэг үүсгэхэд саад болов

Манай сурвалжлах хэсгийн дараагийн очсон газар бол Монгол III дугаар сургууль. Биднийг очих үед өдрийн 01:50 цаг аль хэдийнэ өнгөрсөн байлаа. Энэ цагт бага ангийн сурагчдынхичээлэхэлж, ахлах ангийн сурагчид тарсан байдаг. Гэвч сонгон судлах хичээлтэй учраас ахлах ангийн сурагчид байгаа гэсэн эрмэлзлэлээр тус сургуулийг зорьсон минь энэ. Сургуулийн хашаанд нам гүм байх агаад хажууханд ойрхон байрлах автобусны буудал дээрх хүмүүсийн чимээ л хааяахан сонсогдож байв. Ингээд бид сургалтын менежертэй нь уулзахаар алхтал сургуулийн урд талын сандалд хэсэг охид, хөвгүүд сууж харагдлаа. Тэдэнтэй ярилцвал, XII дугаар ангийн сурагчид бөгөөд “Сонгон судлах хичээл эхлээгүй байгаа. Улирал, улирлаар орно гэсэн. Бараг XII дугаар ангийнханд

ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

сонгон судлах хичээл орохгүй юм шиг байна лээ. Сургуулийн захиргаанаас тийм мэдээлэл өгсөн” хэмээв. Тиймээс бид энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахаар тус сургуулийн захирал В.Хоролгаравтай уулзсан.

Тэрбээр, “Энэ хичээлийн жилээс эхлэн улс орон даяар ахлах ангийн сургалтын цөм хөтөлбөр хэрэгжиж байгаа. Заавал судлах болон сонгон судлах хичээл орж эхэлсэн. Хичээл сонголтын зохицуулалтыг хийхэд ярвигтай. Жишээ авбал, Газарзүйн хичээлийг XII дугаар ангид нийт дөрвөн хүүхэд сонгосон байгаа юм. Биологийн хичээлийг 16 хүүхэд сонгосон. Тэгэхээр энэ хүүхдүүдийн сонголтыг хэрэгжүүлэх боломжгүй болж байгаа юм. Хуульдаа 20 гэсэн байгаа учраас хэрэгжүүлэх боломжгүй. Эндээс харахад, цөөнх болсон хүүхдүүд жоохон хохиролтой байна л даа” гэв. Тус сургуулийн X дугаар анги 40, XI, XII дугаар анги найман бүлгийн 260 сурагчтай аж. Монгол III дугаар сургуулийн захиралтай ярилцсаны дараа бид салбар яамны зүгээс ямар бодлого барьж, үүнд ямар арга хэмжээ авахаар зорьж буйг мэдэхээр БСПУЯ-ны хэвлэлийн төлөөлөгчтэй холбогдож, хариуцсан мэргэжилтнийх нь дутаарыг авсан юм.

А.Энхтогтохоос зарим зүйлд хариулт аваа.

-Хүүхдийн хөгжлийг дэмжсэн сургалын цөм хөтөлбөр үндэсний хэмжээнд хэрэгжиж эхлээд байна. Зарим сургуульд эсрэгээрээ байна л даа. Тухайлбал, олонхын саналыг дагаж, хичээл сонголтыг хийлгэж байна. Үүнээс болж зарим сурагчид өөрийн сонирхсон хичээлийг сонгох боломжгүй нөхцөл байдал үүсч байна. Үүнд нэгдсэн журмаар зохицуулалт хийх боломж бий юу?

-Ахлах ангид заавал судлах, заавал сонгон судлах, сонгон гүнзгийрүүлж судлах хөтөлбөр хэрэгжүүлэхээр боловсруулагдсан байгаа. Бүрэн дунд болосврол эзэмшихэд зайлшгүй шаардлагатай хичээлүүд заавал судлах хөтөлбөрөөр хичээллэнэ. Харин заавал сонгон судлах хичээл нь орон нутаг болон сургуульд эрх мэдэл олгосон, сургууль, орон нутгийн хөгжлийг дэмжсэн, сургуулийн бодлого зорилтод нийцүүлэн үндэсний хэмжээнд гарсан бүрэн дунд боловсролд хэрэгжих хөтөлбөр буюу тавигдах шаардлагын дагуу сургууль хөтөлбөрөө боловсруулан хэрэгжүүлэх юм. Сонгон гүнзгийрүүлэн судлах гэдэг нь шинжлэх ухааны мэдлэг ойлголтыг



боловсрол эзэмшихэд зайлшгүй үзэх ёстой хичээлээ судлаад сонгосон судлагдахуунаа нэмж судлах юм. Гэхдээ цөөн сурагчтай сургууль хүүхдийн сонголтоор бүлэг үүсгэх боломжгүй бол багшлах боловсон хүчний нөөц, орон нутгийн хөгжил, сургуулийн зорилго зорилтод үндэслэн сургуулийн менежментийн зохицуулалт хийж болно. Сургуулийн дотоод үйл ажиллагаанд оролцож үндэсний хэмжээнд нэгдсэн зохицуулалт хийх

боломжгүй. Энэ нь тухайн сургуульд эрх мэдэл олгож байгаа гэсэн үг юм. **-Олонхын жишгийг дагаад үлдсэн хүүхдүүд нь хохироод үлдэнэ гэсэн үг үү?** -Өнгөрсөн жил бид лаборатори 40 сургуульд туршиж үзсэн үр дүнгүүд бий. Тухайлбал, хүүхдүүд заавал судлах хичээлээ судалчихаад сонгон гүнзгийрүүлэх хичээлээр сонголтын бүлэг үүсгэн хичээллэж болно. Гэхдээ хүүхдийн сонголтыг

хүндэтгэж, зохицуулалт хийх арга хувилбаруудыг сургуулийн менежментийн сургалтаар захирал, менежерүүдэд сургалт өгсөн байгаа. Түүнээс гадна сургуулийн төсөвт тохируулан багшлах боловсон хүчнийхээ нөөцөөс хамаарч зохицуулалт хийх эрх сургуулиудад бий. Тэгэхээр хүүхдийн сонголтыг харгалзах, багшлах боловсон хүчнийхээ нөөцөд үндэслэх, сургуулийн менежментийн зохицуулалтыг хийнэ гэх мэт зохицуулалт хийх хувилбарууд байгаа гэсэн үг. Сурагчдынхаа сонголтыг хараад олонх хүүхэд ямар хичээл сонгосон байна тэрнийг дэмжинэ. Хэрвээ цөөн хүүхэд нэг хичээл сонгосон бол олон бүлэгтэй сургуулиудад тэднийг нийлүүлж бүлэг үүсгэх боломжтой.

-Анх энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд судалгааны ажил хийсэн байх. Хөдөө орон нутаг болон нийслэл дэх сурагч, бүлгийн тоо харилцан адилгүй шүү дээ. Тухайн үед энэ талаас нь судалж үзээгүй юм уу?

-Хөдөө орон нутагт хоёр бүлэгтэй сургуульд хүүхдийн сонголтоор явах боломжтой. Тэр хувилбарыг сургуулийн менежментийн сургалтаар танилцуулсан байгаа. Нэг бүлэгтэй сургуульд зайлшгүй сургуулийн зохицуулалт орж ирж байгаа. Учир нь сонголтод үндэслэхэд бүлэг дүүргэлтийн тоо хүрэхгүй асуудал гарч байгаа.

-Нэг бүлэгтэй сургуульд зайлшгүй сургуулийн зохицуулалт орж ирнэ гэлээ. Нийслэлд олон бүлэгтэй сургуульд тухайн хүүхэд бусдаасаа шалтгаалаад өөрийн сонирхсон хичээлийг сонгон гүнзгийрүүлж судлах боломжгүй байна шүү дээ?

-Олон бүлэгтэй сургууль сурагчдынхаа сонголтоор бүлэг үүсгээд явах боломжтой. Анх удаа хэрэгжиж байгаа учраас асуудлууд гарч ирэх байх. БСШУС-ын яамнаас бэлтгэл хангах хоёр сарын бэлтгэл хугацааг сургуулиудад өгсөн байгаа. Нэгдүгээр улирлыг дуустал бэлтгэл зохион байгуулалтаа хийх тушаал гарсан. Түүний дагуу сургуулиуд бэлтгэлээ хийн хүүхдүүдийнхээ сонголтыг авч, сонголтын дагуу төсөвтөө багтаан сургалт явуулах нөхцөл боломжийг эрж хайж олох юм. Тэр хугацаанд бүх бүрэн дунд боловсролын сургуулиас мэдээлэл авна. Мэдээллийг аравдугаар сарын 20 хүртэл авч үр дүнд шинжилгээ хийж үзнэ.

Тэр үед үр дүн нь гарчихна. **-Заавал 20 хүүхэд бүрдүүлж хичээл заана гэх юм. Энэ шаардлагаас болж зарим сургуульд бүлэг бүрдэхгүй байна шүү дээ?** -Тэр бол гурван яамны сайдын хамтарсан тушаал байдаг. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Сангийн сайд, Хөдөлмөрийн сайдын гаргасан тушаал байгаа юм. Уг тушаалд 25 хүүхэдтэй байж нэг бүлэг үүсгэн сургалт явуулна гэсэн байдаг. Тушаалын дагуу хууль эрхзүйн хүрээнд хэрэгжүүлж байгаа.

Ядаж нийслэл дэх сургуульдаа зохицуулалт хиймээр юм

Гурван сургуулиар ороход бодит байдал ийм л байна. Дэлхий нийт суралцагчийг бие даан, бүтээлчээр суралцахууд суралцах боломж олгох, цаашид дээд болон мэргэжлийн боловсрол эзэмшихэд бэлтгэх, мэргэжлийн чиг баримжаа олгох хөтөлбөрөөр дамжуулан мэдлэгт суурилсан тогтвортой хөгжлийг дэмжигч, бүтээлч иргэдийг төлөвшүүлэхийг зорьж буй. Манай улс ч энэ жишгийг дагаж бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөрийг сурагчдад сонголт хийх өргөн боломжтойгоор боловсруулан хэрэгжүүлэхээр ажиглаж байгаа юм. Уг нь ахлах сургуулийг хөгжүүлэх цөм хөтөлбөр үргэлжлэн хэрэгжвэл хүүхдүүдэд олон давуу талтай гэдгийг хэн бүхэн мэднэ. Тиймээс дөнгөж эхэлж байгаа учраас гэж шалтгаан хүүхдүүдийг хохироож болмооргүй. Нэгэнт хүүхдийн сонголтыг хүндэтгэнэ гээд хөтөлбөртөө заачихсан үндэсний хэмжээнд хэрэгжиж байгаа юм чинь хүүхдийн эрхийг зөрчилгүй, аль нэгийг нь алагчилж үзэхгүй байвал зүгээрсэн. Сайдын тушаал өөрчлөх, сургуулийн төсвийг нэмэгдүүлэх тал дээр арга хэмжээ авч болохгүй байж болох. Гэхдээ хөдөө нутгийн биш юм гэхэд хүн амын нягтаршил, сурагчид ихтэй нийслэлийн сургуулиудад нэгдсэн зохион байгуулалтад оруулж, бүлэг үүсгэлт хийлгэчихмээр юм. Ингэвэл ядаж л хүүхэд өөрийн сонирхсон хичээлээ судалж, цөм хөтөлбөрт бүрэн хамрагдаж чадна. Эс бөгөөс олонхыг дагасаар бусад хүүхдүүд цөм хөтөлбөрийн золиос болох нь...



ТАЛ НУТГИЙН ЦАХИМ МЭДЭЭЛЭЛ

MMINFO АПП

Тал нутгийн өдөр тутмын мэдээ мэдээлэл таны гарт...



TATAX PLAY STORE



TATAX APP STORE





Оддын Амьдрал

КЭЙТ АПТОН:

Таднаас чинь хараад хэрхэн
өөлж буйгаар өөрийгөө
өөрчлөх хэрэггүй

Орчуулсан: Б.ДАВААХҮҮ

Загварын ертөнцөд цахиур хагалж яваа үзэсгэлэнт бүсгүйн ярилцлагыг энэ удаагийн “Оддын цаг” буландаа орчуулан хүргэж байна. Салбартаа хамгийн их ашиг орлоготой, хамгийн үзэсгэлэнтэй бүсгүйчүүдийн тоонд зүй ёсоор багтдаг Кэйт Аптон өөрийн амьдралынхаа талаар ийнхүү ярьжээ.

—Та багын л загвар өмсөгч болох мөрөөдөлтэй байв уу?

—Загварын талаар ямар ч төсөөлөлгүй өссөн. Ямар сайндаа Флоридад тавчик, бикини хослуулж өмсөөд явж байх вэ дээ. Хүүхдүүдтэй харилцахдаа их догшин. Тэд намайг урт хөлтэй, сэргвэр өтгөн хөмсөгтэй гэж их шоолдог байлаа. Нэг удаа ээж минь сэтгүүл үзэж байгаад “Хараач загвар өмсөгчид нь яг л чам шиг юм байна” гэж хэлж билээ. Тэр үеэс би загвар өмсөгч болохоор шийдсэн.

—Тэгээд хэзээнээс ажлын гараагаа эхлүүлж байв?

—Хамгийн анх Миами сэтгүүлд зургаа авхуулж байсан. Тэр үед фитнес зааланд зураг авах байсан юм. Бид өглөө гурван цагт тэнд очоод, үдээс хойш 15.00 цаг хүртэл байсан. Гэвч нэг ч удаа хоол идээгүй. Ер нь бол моделиуд

туранхай байдгийг гайхах хэрэггүй.

—Та хэзээнээс алдартай болж эхэлсэн бэ. Өмнө нь загвар өмсөгч хүний байх ёстой биеийн харьцаатай биш гээд хасагдаж байсан гэж сонссон юм байна. Хэн нэгэн танд жингээ хэрхэн хаях талаар зөвлөж байсан уу?

—Ер нь бол байнга. Би эхлээд яг тэдэн шиг болохын тулд хоолны дэглэм барьсан юм. Гэхдээ эцэст нь тийм ч сайн үр дүн гараагүй. Тиймээс илүүдэл жингээ өөр аргаар хаях ёстой болсон л доо. Ер нь хүнд алсын хараа, бүтээлч чанар хоёр өчүүхэн байхад л өөрөө өөрийгөө өөрчилж чаддаг гэж боддог.

—Хүн өөрөө өөрийгөө хараад сэтгэл хангалуун байх ёстой. Ийм мэдрэмж танд хэзээнээс төрж байв?

—Өсвөр насандаа усны хувцастай махлагдуу биеэ сайхан гэж боддог байсан юм шүү. Харин ажил хийж эхлэх үед, би каталоогоор ихэвчлэн захиалга авдаг байсан юм. Гэтэл хүмүүс гадаад төрхийг минь “загвар өмсөгчийнх шиг галбиргүй юм” гэх зэргээр өөлөх болсон. Тэр үед би яагаад ер нь өдөр бүр энэ ажлыг хийж байгаа юм бэ гэж өөрөө өөрөөсөө асууж билээ. Ер нь загварын ертөнцөд маш олон өөр өөр загварчлал бий. Амжилтад хүрэх маш олон зам байна.

—Танд ч гэсэн амжилтад хүрэх маш олон зам байсан байх. 2013 онд гэхэд та Vogue, Sports Illustrated swimsuit issue сэтгүүлүүдийн нүүрийг чимж байсан шүү дээ?

—Тэр үнэхээр сайхан мөч шүү. Яг үнэнийг хэлэхэд, намайг загварын ертөнцөд тохирох, тохирохгүйг шүүсэн хүмүүсийн яриа надад том боломж өгсөн байх. Учир нь би хамгийн эрүүл гоолиг, хамгийн сайхан харагдах ёстой болохоос биш хэн нэгэнд нийцүүлэх гэж модель болдоггүйг харуулахыг хүссэн. Ер нь хэн нэгэн чамайг гаднаас чинь хараад хэрхэн өөлж буйгаар өөрөө өөрийгөө өөрчлөх хэрэггүй.

—Dougie видеоогоор социал медиад хүчээ авсан анхны загвар өмсөгчдийн нэг нь та. Энэ магадгүй таныг нэрд гарахад тусласан байх. Харин одоо социал медиаг та хэрхэн ашигладаг вэ?

—Өдрийн төлөвлөсөн ажилд саад учруулахгүй байдлаар хүмүүстэй ярилцах, эсвэл ямар нэг зүйлийн талаар бодож, эргэцүүлэх байдлаар ашиглахыг хичээдэг. Гэхдээ би тэр бүр ажлыг урьдчилан төлөвлөөд байдаггүй юм. Заримдаа амьдралаас мэдрэх таашаал, түүнээс ч илүү чухал зүйлсийн талаар постлох сайхан мөчүүдээ алдчихаад байгаа юм шиг санагддаг.

—Та нохой тэжээдэг. Бас бэйсбол тоглож буй зураг чинь социал медиад их байдаг юм билээ. Ямар нэг зорилготой юм биш биз?

—Тийм. Хүмүүс заримдаа надад зөвлөгөө өгдөг л юм. “Чи сельфи хийгээд түүнийгээ социал хуудастаа байршуулаад, хэдэн лайк авахыг нь үзээч” гэдэг. Гэхдээ би өөрт хөгжилтэй санагдсан зүйлс, эсвэл сургамжит үгсийг илүүтэй постолдог. Хүмүүс намайг юу постолж буйг л харахыг хүсдэг байх. Түүнээс бусад зүйлсийг тэр бүр сонирхоод байдаггүй болов уу. Би өөрийн постод бага зэргийн шүүлтүүртэй байхыг эрхэмлэдэг.

—Өөрийг тань үзэн ядагчдын тухайд юу хэлэх вэ. Таны талаархи сөрөг сэтгэгдлүүдийг уншдаг л биз дээ?

—Эхэндээ хэцүү байдаг байсан. Гэхдээ одоо бол тийм биш. Би заримдаа өөрийнхөө талаархи сөрөг сэтгэгдлүүдийг уншдаг. Тэднийг их хөгжилтэй хүмүүс гэж боддог шүү. Энэ надад асуудал болдоггүй.



ИЛҮҮ ИХИЙГ БҮТЭЭХ ХҮЧ

INSPIRON 5000 SERIES



БИД ТАНЫ АЖЛЫГ ХӨНГӨВЧИЛНӨ

Inspiron 15 5000 загварын нөүтбүүкүүд нь таны хэрэгцээнд тохируулсан Full HD дэлгэц, гайхалтай график үзүүлэлт, Intel® Core i5 процессортой учир таны төсөөлснөөс ч илүүг бүтээж чадна.

Онцгой урамшуулал

Dell брэндийн нөүтбүүк худалдан аваад Targus брэндийн үүргэвчийг бэлгэнд аваарай.



Бэлгэнд

- Үүргэвч
- 2 жилийн баталгаа
- McAfee вирусын програм

www.facebook.com/PCmallOfficial
www.instagram.com/PCmall_Official

Биднийг
дагаарай



7575-3535